



Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2006-2008 оны нэгтгэлийн тайлан

(Хураангуй хувилбар)

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын алба
Улаанбаатар хот, 2011 он

Холбогдох хаяг: МОНПО-ын ажлын алба, СБД дүүрэг, Амарын гудамж, Туушин компанийн байр, 512 тоот өрөө
Утас: 976-70110525, Факс: 976-70110155, Имэйл: eiti.secretaria.mn@gmail.com, Вэб: www.eitimongolia.mn

Өмнөх үг

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага нь Засгийн газар, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл хамтран олборлох үйлдвэрлэл /газрын тос, хий, болон уул уурхай/ компани нь төлсөн материаллаг төлбөрөө, Засгийн газар хүлээн авсан материаллаг орлогоо ил тод хэвлэн нийтлүүлэх, нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог бий болгон хөгжүүлэхийг дэмжсэн үйл ажиллагаа юм. Зорилго нь олборлох үйлдвэрлэлээс бий болгосон орлогыг ил тод болгох, энэхүү орлогыг үр дүнтэй, нийгэмд үр ашигтай байдлаар зарцуулах бололцоог улам сайжруулах, аливаа улсын олборлох үйлдвэрлэлээс нөөцийг хөгжүүлэх явцад бий болсон хөрөнгийг буруу зорилгоор ашиглах эрсдэлийг багасгахад оршиж байна.

Монгол Улсын Засгийн газар энэхүү ОУИТБС-д нэгдэх шийдвэрээ 2006 онд гаргасан билээ. Үүний дагуу ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийг Засгийн газар, уул уурхайн компани, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан байгуулж, Санаачлагыг хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх гарааны санхүүжилтийг олон талт хандивлагчдын Итгэлийн сангаас гаргаж, захиран зарцуулах үүргийг Дэлхийн Банк хүлээж байна. Ажлын хэсэг нь ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулан Үндэсний зөвлөлөөр батлуулж, уул уурхайн компаниас улс, орон нутгийн /улс, аймаг, нийслэл, дүүрэг, сум/ төсөвт төлсөн, Засгийн газар уул уурхайн компаниудаас хүлээн авсан орлогын тайланг батлагдсан маягтын дагуу 4 жил дараалан гаргаж ирлээ. ОУИТБС-ын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулдаг цомхон ажлын алба ажиллаж байна.

Монгол Улс ОУИТБС-ын 2006, 2007, 2008 оны тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар гаргуулсан бөгөөд уншигч олон Та бүхэнд эдгээр тайланг хураангуйлан толилуулж байна. Эдгээр тайлангуудын дэлгэрэнгүйг ОУИТБС-ын ажлын албаны www.eitimongolia.mn цахим хуудаснаас татан авах бүрэн бололцоотой.

2006-2009 онд Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлсэн байдалд олон улсын баталгаажуулалт хийгдэж, Монгол Улсыг ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан 4 дэх орноор 2010 оны 10 дугаар сарын 15- ны өдөр Олон улсын удирдах хороо хүлээн зөвшөөрсөн байна.

Бид олборлох үйлдвэрлэлийн зөвхөн төлбөр, орлогыг л ил болгоод байгааг анхаарна уу. Цаашдаа тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл, борлуулалт, гэрээний ил тод байдлыг алхам алхамаар хангах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монголын Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч
Б. Долгор

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Тайлан

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (цаашид ОУИТБС гэнэ)-ын нэгдсэн тайлан гэдэг нь нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд тухайн санхүүгийн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн хэмжээг тайлагнаж нөгөө талаас Засгийн газар компаниудаас улсын болон орон нутгийн төсвөөр дамжуулан хүлээн авсан татвар, төлбөрийнхөө орлогыг тайлагнадаг бөгөөд улмаар 2 талаас ирүүлсэн тайланг нэгтгэж мэргэжлийн хөндлөнгийн аудитор тодруулга хийж, баталгаажуулсан Монгол Улсын тайланг хэлнэ.

Монгол Улсын ОУИТБС-ын анхдугаар тайлан 2006 онд гарсан бөгөөд 2006-2008 он хүртэл нийт 3 удаагийн нэгдсэн тайлан гаргаад байна. Жил бүр тайлан гаргах компанийн тоо нэмэгдсээр байгаа бөгөөд тайлангийн тайлбарлаагүй үлдсэн зөрүүний хэмжээ багасаж байгаа нь тайлангийн нэг чухал ололт юм.

	2006 он	2007 он	2008 он	2009
Засгийн газрын тайланд орсон компанийн тоо	134	134	184	363
Тайлан гаргасан компанийн тоо	64	102	113	129
Үүнээс:				101
Аудитын нэгдсэн тайланд орсон компаниудын тоо	25	38	46	
Материаллаг төлбөрийн босго	200 сая төгрөг	200 сая төгрөг	100 сая төгрөг	50 сая төгрөг
Шийдэгдээгүй зөрүү /төгрөг/	25 тэрбум 4 тэрбум*	775 сая	420 сая	58,1 сая
Нэгтгэл хийсэн аудитын консорциум	Крэйн Вайт энд АссошиэТС - Австрали	Эрнст энд Янг – Малайз, Монгол	Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британийн Харт Нойрс Лтд	Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британийн Харт Нойрс Лтд

**Жич: 2006 оны анхдугаар нэгдсэн тайлангийн шийдвэгдээгүй зөрүү 25 тэрбум байсан боловч хожим тайлан гарсны дараа үүний 21 тэрбум төгрөг нь тайлбарлагдсан бөгөөд 4 тэрбум нь тайлбарлагдаагүй хэвээр байна.*

Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайланг олон улсын мэргэшсэн нягтлан бодох, аудитын компани 2006 оны тайланг Австрали улсын “Крэйн Вайт энд АссошиэТС” компани, 2007 оны тайланг Монгол, Малайз улсын “Эрнст энд Янг Аудит Монгол” ХХК-ийн консорциум, 2008 оны тайланг Англи Улсын “Харт Нойрс лтд”, Монгол улсын “Улаанбаатар аудит корпораци” компанийн консорциум хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн үрсгал – харьцуулалт

	2006	2007	2008	2009
Улсын нэгдсэн төсвийн орлого	1,354,0	1,855,9	2,170,0	1,994,0
Үүнээс: Татварын орлого	1,128,1	1,502,3	1,890,9	1,972,6
Үүнээс: компанийн төлсөн татвар	492,2	690,5	682,6	737,6
Татварын орлогод эзлэх хувийн жин	44%	46%	36%	37,4%

Дээрх хүснэгтээс харахад 2006-2009 оны Улсын төсвийн гүйцэтгэлийн татварын орлогын 36-46 хувийг ОУИТБС-ын тайланд хамрагдсан 25-101 компанийн төлсөн татвар, төлбөр бүрдүүлж байгаа бөгөөд тийм хэмжээний орлогыг ОУИТБС-ын Монгол Улсын тайлангаар ил тод болгожээ.

2006 оны нэгдсэн тайлан

Монгол Улсын 2006 оны тайланд 200,0 сая-аас дээш материаллаг төлбөр төлсөн 25 компанийн, тэдгээрээс ЗГ-ын хүлээн авсан орлогыг хамруулсан болно. Энэхүү тайлангаар компаниуд 492,2 тэрбум төгрөгийн татвар, төлбөр төлснөө нотолсон бол Засгийн газар 467,1 тэрбум төгрөгийн орлогоо нотолж чадсан юм (Хүснэгт 1-ээс үзнэ үү).

Тайланг нэгтгэхэд гарсан зөрүү

Шийдэгдээгүй гол зөрүүнүүд татвар (-552,1 сая), төлбөр (-20,0 тэрбум), засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламж (-3,7 тэрбум) гэсэн хэсгүүдэд гарсан.

Татварын төрөлд хамгийн их шийдэгдээгүй зөрүү нь буцаан авснаа хассан НӨАТ (-1.4 тэрбум), аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (2,0 тэрбум), автобензин, дизелийн түлшний албан татвар (-1,0 тэрбум) байв.

- Дотоодын зах зээлээс бараа, үйлчилгээ худалдан авах, импортоор бараа оруулах тохиолдолд НӨАТ төлдөг ба харин уул уурхайн компани ашигт малтмал экспортлох тохиолдолд НӨАТ-ын буцаан авалт үүсдэг. Үүнийг өмнөх өрийн үлдэгдлээс хааж болох ба буцаан авалтын өрийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад татварт суутган тооцож болдог. Гэвч ОУИТБС-ы маягт дээрх зааварчилгаа нь НӨАТ-тай холбоотой зүйлсийг хэрхэн тайлагнах талаарх мэдээллийг нарийвчлан оруулаагүйн улмаас компаниуд өөр өөрийн үзэмжээр тайлагнаж, энэ хэсэгт их хэмжээний зөрүү гарсан. Гэхдээ сайтар тодруулсны үндсэн дээр их хэмжээний зөрүүг бага хэмжээний болгож залруулсан болно.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд мөн адил НӨАТ-ын буцаан авалтыг суутган тооцоогүйн улмаас зөрүү гарсан.
- Автобензин, дизель түлшний албан татварын хувьд зөрүү гарсан тухайн компани ажлын ачааллаас хамааран ямар нэгэн тодруулга өгөх боломжгүйгээс болсон.

Төлбөрийн хувьд ашигт малтмалтын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр (-7,7 тэрбум), нөөц ашигласны төлбөр (-1,1 тэрбум), улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр (-1,8 тэрбум), газрын төлбөр (-7,2 тэрбум), гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр (1,6 тэрбум) зэргүүд дээр Засгийн газрын зүгээс компаниудын хийсэн төлбөрийг хүлээн авсан талаараа тайлагнаагүйн улмаас их хэмжээний зөрүү гарсан. Энэ зөрүү тайлбарлагдаагүй хэвээр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн хувьд Эрдэнэт компани 2006 оны 12 сарын 29-ны өдөр ногдол ашгийг шилжүүлсэн боловч банкны гүйлгээ 2007 оны 01 сарын 02-ны өдөр төрийн дансанд орсон тул Засгийн газар 2006 оны тайланд тусгаагүйн улмаас их хэмжээний зөрүү гарч байсан. Гэхдээ энэ зөрүүг тодотгож маш бага хэмжээний зөрүү үлдсэн болно.

Хандив тусламжийн хувьд компаниуд үзүүлсэн мөнгөн болон мөнгөн бус хандив тусламж бүгдийг нь тайлагнасан бол Засгийн газрын харъяа яам, агентлагууд, аймаг, сум, орон нутгийн байгууллагууд хандив тусламж хүлээн авснаа бүрэн тайлагнаагүйгээс их хэмжээний зөрүү гарсан. Учир нь ялангуяа аймаг орон нутгийн түвшинд мөнгөн бус хэлбэрээр үзүүлсэн хандив тусламжийг бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж байгаагүй юм.

Жич: 2006 оны анхдугаар нэгдсэн тайлангийн шийдвэгдээгүй зөрүү 25 тэрбум төгрөг байсан боловч хожим тайлан гарсны дараа Сангийн яамны зүгээс үүний 21 тэмбум төгрөгийн тайлбарыг Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулсан байдаг.

Аудиторын санал, зөвлөмж (Авсрали улсын Крэйн Вуайт Ассошиэтс компани)

- **Маягт бөглөх зааварчилгаа** Шийдэгдээгүй зөрүү нь маягтыг буруу, дутуу бөглөсний улмаас гарч байгаа тул ОУИТБС-аас маягтыг бөглөх зааварчилгааг маш сайн нарийвчлан өгөх;
- **Шийдэгдээгүй зөрүү** Цаашид өмнөх оны гарсан зөрүүний учир шалгааныг тогтоохоос илүүтэйгээр дараа дараагийн жилд зөрүүгүй байх талаас нь үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;
- **ЗГ-ын мэдээлэх систем** Бүх төрийн байгууллагууд (ялангуяа аймаг, сум, орон нутаг) төлбөр хүлээн авснаа харьяа удирдах байгууллагадаа тогтмол мэдээлэх мэдээллийн зохистой системтэй байх;
- **Хандив, тусламж** Төрийн байгууллагад үзүүлсэн мөнгөн болон мөнгөн бус тусламж, хандивыг нарийвчлан бүртгэдэг байх (уул уурхайн компаниуд мөнгөн бус хандив тусламж үзүүлэх тухай бүрдээ хүлээн авагч талаар бөглүүлдэг буюу баталгаажуулдаг хуудастай байх гэх зэрэг энгийн аргаар үзүүлсэн мөнгөн бус тусламжийн бүртгэлийг сайжруулах);
- **НӨАТ** нь ихээхэн ээдрээтэй татварын төрөл тул тайлангийн нэгтгэлээс хасаж болно;
- Эсвэл НӨАТ-тэй холбоотой илүү нарийвчилсан нэмэлт тайлбарыг маягтад оруулах (гааль дээр төлж байгаа НӨАТ, НӨАТ-ыг бусад төрлийн татварт суутган тооцох, дотоодын бараа үйлчилгээ худалдан авахад төлсөн НӨАТ гэх мэт дотор нь ангилж тайлбарлах);
- **Гаалийн татвар** дээр их зөрүү гарч байна. Тиймээс энэ хэсэгт зааварчилгааг маш сайн өгөх. Компаниуд гаальд төлсөн татварыг бүхэлд нь нэгтгэн бүртгэдэг тул ялгаж салгахад бэрхшээлтэй байна. Гаалийн үйлчилгээний хураамжийг тайлангаас хасч болох юм;

Хүснэгт 1. 2006 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (татвар, төлбөрийн төрлөөр)

Бүлэг	Компани	Засгийн газар	Анхны зөрүү	Залруулга		Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүү
				Компани	Засгийн газар	Компани	Засгийн газар	
Татвар	333 583 355	324 333 668	(9 249 687)	(6 874 918)	1 822 643	326 708 437	326 156 311	(552 126)
Төлбөр	60 607 740	42 288 902	(18 318 838)	1 149 796	(601 918)	61 757 536	41 686 984	(20 070 552)
Хураамж, үйлчилгээний шимтгэл	2 211 858	-	(2 211 858)	17 605	1 554 886	2 229 463	1 554 886	(674 577)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	98 440 436	38 337 637	(60 102 799)	(950 000)	59 151 641	97 490 436	97 489 278	(1 158)
Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөр	3 012 958	2 671	(3 010 287)	(3 007 940)	-	5 018	2 671	(2 347)
Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив	4 236 863	303 469	(3 933 394)	(140 000)	-	4 096 863	303 469	(3 793 394)
Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал								
Нийт	502 093 210	405 266 347	(96 826 863)	(9 805 457)	61 927 252	492 287 753	467 193 599	(25 094 154)

2006 оны тайланд ороогүй

Хүснэгт 2. 2006 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (компаниар)

№	Компани	Компани	Засгийн газар	Анхны зөрүү	Залруулга		Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүү
					Компани	Засгийн газар	Компани	Засгийн газар	
1	Адуунчулуун	263 622	253 810	(9 812)	-		263 622	253 810	(9 812)
2	Айвенхоу Майнз монголиа	9 433 535	1 558 946	(7 874 589)	-	21 492	9 433 535	1 580 438	(7 853 097)
3	Алтан дорнод монгол	6 602 335	3 879 604	(2 722 731)	-	741 505	6 602 335	4 621 109	(1 981 225)
4	Багануур	3 461 022	3 558 023	97 001	-		3 461 022	3 558 023	97 001
5	Бороо гоулд	11 546 790	5 208 579	(6 338 211)	(4 647 936)		6 898 854	5 208 579	(1 690 275)
6	Гацуурт	2 043 194	2 054 916	11 722	-	581 262	2 043 194	2 636 178	592 983
7	Дацан трейд	473 738	257 220	(216 518)	54 445	238 209	528 183	495 429	(32 755)
8	Жамп	696 604	618 069	(78 535)	1 104 511	(235 724)	1 801 115	382 345	(1 418 770)
9	Коулд гоулд	309 511	286 602	(22 909)	-	(99 365)	309 511	187 237	(122 274)
10	МАК	1 063 208	767 504	(295 704)	947 455	154 981	2 010 663	922 485	(1 088 178)
11	Монгол газар	77 889	275 364	197 475	852 195		930 084	275 364	(654 719)
12	Монголросцветмет	1 883 080	902 599	(980 481)	-	(2 929)	1 883 080	899 670	(983 410)
13	Петро Чайна Дачин Тамсаг	3 958 905	46 444	(3 912 461)	(3 007 940)	16 049	950 965	62 493	(888 472)
14	Тавантолгой	4 266 361	4 451 988	185 627	-		4 266 361	4 451 988	185 628
15	Улз гол	634 622	498 465	(136 157)	(110 686)		523 936	498 465	(25 471)
16	Цайрт минерал	4 197 473	5 831 067	1 633 594	(983 105)		3 214 368	5 831 067	2 616 699
17	Чинхуй МАК Нарийн сүхайд	2 610 141	874 639	(1 735 502)	(100 500)	1 554 886	2 509 641	2 429 525	(80 116)
18	Шарын гол	1 221 763	608 111	(613 652)	(598 132)		623 631	608 111	(15 521)
19	Шивээ-Овоо	1 076 349	1 039 224	(37 125)	-		1 076 349	1 039 224	(37 125)
20	Шижир алт	6 296 953	4 658 998	(1 637 955)	(845 575)	112 486	5 451 378	4 771 484	(679 894)
21	Шим технологи	324 267	305 197	(19 070)	49 178		373 445	305 197	(68 247)
22	Шинь Шинь	744 270	15 370	(728 900)	50 883		795 153	15 370	(779 783)
23	Эм жи эйч	842 884	686 811	(156 073)	(286 344)	7 648	556 540	694 459	137 919
24	Эрдэнэт УБҮ	437 677 031	366 311 270	(71 365 761)	(2 283 567)	59 151 641	435 393 464	425 462 911	(9 930 552)
25	Эрдэс холдинг	387 665	317 526	(70 139)	(339)	(314 888)	387 326	2 638	(384 689)
	Нийт	502 093 212	405 266 346	(96 826 866)	(9 805 457)	61 927 253	492 287 755	467 193 598	(25 094 153)

2007 оны нэгдсэн тайлан

Монгол Улсын 2007 оны тайланд 200,0 сая төгрөгөөс дээш төлбөр төлсөн 38 компани, тэдгээрээс Засгийн газрын хүлээн авсан орлогыг хамруулсан юм. Энэхүү тайлангаар компаниуд 750,0 орчим тэрбум төгрөгийн татвар, төлбөр төлснөө нотолсон бол Засгийн газар 750,0 орчим тэрбум төгрөгийн орлогоо нотолж чадсан юм. (Хүснэгт 3-аас үзнэ үү)

Тайланг нэгтгэхэд гарсан зөрүү

Шийдэгдээгүй зөрүү 11,5 тэрбум төгрөг байсан боловч Алтан дорнод монгол ХХК-ийн 10,7 тэрбум төгрөгийн татварын асуудал олон улсын арбитрын болон дотоодын шүүх дээр маргаан нь явагдаж байсан тул тайлангийн зөрүүгээс хасагдаж эцсийн шийдэгдээгүй зөрүү нь 775 сая төгрөг болсон.

Гол зөрүүнүүд төлбөр, хураамж үйлчилгээний хөлс, байгаль орчин хамгаалахад зарцуулсан зардал, засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламж гэсэн хэсгүүдэд гарсан.

Татварын хэсэгт голчлон гаалийн албан татвар, импортлосон шатах, тослох материалын онцгой албан татвараас болж гарсан. (-42,3 сая)

Төлбөрийн хэсэгт илэрсэн зөрүүнүүд голчлон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ба улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулийн ажлын нөхөн төлбөрөөс болж гарсан. (-937,3 сая)

Хураамж, үйлчилгээний хөлсний хувьд зөрүү нь Бороо гоулд болон Петро чайна дачин тамсаг компаниуд холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн үйлчилгээний хураамжид тайлагнасан дүнгийнхээ талаар нэмэлт мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байснаас үүссэн. (-262,6 сая)

Аудиторын санал, зөвлөмж (Малайзын Эрнст энд Янг, Монгол улсын Эрнст энд Янг Монголиа компанийн консорциум)

- **Цаг хугацааны хувьд** тодруулга хийх ажиллагааг амралт, баяр ёслолын өдрүүдтэй давхцуулахгүй байх, компаниуд, засгийн газрын нэгж байгууллагуудын холбогдох гол хүмүүс эзгүй байх үед тэднийг орлох хүмүүсийг томилсон байх
- **Засгийн газрын гарган өгч буй мэдээллийн бүрэн, үнэн зөв байдлыг хангах** үүднээс хяналт тавьж ажиллах үүргийг Сангийн яаманд хариуцуулах
- **ЗГ-ын мэдээлэх систем** Уул уурхайн компаниудаас хүлээн авсан газрын төлбөр, ус ашигласны төлбөрийн талаарх мэдээллийг сум тус бүр тогтмол үндсэн дээр бэлтгэн аймгуудад хүргүүлж, нэгтгүүлж байх
- **Хандив, тусламжийн** мэдээг нарийвчлан гаргаж тогтмолжуулах
- **ОУИТБС-аас маягт бөглөх зааварчилгааг нарийвчлах**
- **Засгийн газрын** хүлээн авсан төлбөрөө тайлагнах явцад хэд хэдэн байгууллага оролцож байгаа тул **мэдээллийн иж бүрэн байдлыг баталгаажуулахын** тулд Сангийн яам бодитой идэвх зүтгэлтэй ажиллах
- ОУИТБС-ын маягт бөглөх үед хүндрэл, асуулт гарах үед холбогдох байнгын туслах ажилтанг томилох
- **Гаалийн татвар, гаалийн үйлчилгээний хураамж, байгаль хамгаалахтай холбоотой зардлуудыг** хамтатган бүртгэсний улмаас нарийвчлан задлах боломжгүй байсан тул хожим ийм хүндрэл дахин гаргахгүйн тулд уул уурхайн компанийн нягтлан бодогч нар тусгайлан зохих ёсны зааварчилгаа, удирдамж боловсруулан гаргах

Хүснэгт 3. 2007 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (татвар, төлбөрийн төрлөөр)

Бүлэг	Компани	Засгийн газар	Анхны зөрүү	Залруулга	Шийдэгдээгүй зөрүү	Залруулга	Шийдэгдээгүй зөрүү
Татвар	518 023 089	485 995 569	(32 027 520)	23 844 798	(8 182 722)	8 140 373	- 42 349
Төлбөр	123 453 990	108 739 039	(14 714 951)	12 254 090	(2 460 861)	1 523 556	- 937 305
Хураамж, үйлчилгээний шимтгэл	2 230 353	22 397	(2 207 956)	1 936 604	(271 352)	8 745	- 262 607
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	79 662 181	138 635 635	58 973 454	(58 973 454)	-		-
Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөр	11 673 994	7 690 371	(3 983 623)	3 983 623	-		-
Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив	3 016 451	1 776 238	(1 240 213)	1 100 106	(140 107)	339 426	199 319
Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	6 944 238	5 923 712	(1 020 526)	507 491	(513 035)	780 834	267 799
Нийт	745 004 296	748 782 961	3 778 665	(15 346 742)	(11 568 077)	10 792 934	(775 143)

Шийдэгдээгүй зөрүү: анхны зөрүү **3 778 665** мянган төгрөг байсныг залруулга хийхэд **11 568 077** мянган төгрөг болж өссөн боловч Алтан дорнод монгол ХХК, Тун шин ХХК мэдээлэл гаргаж өгөх боломжгүй, татварын маргаан нь олон улсын арбитрын болон дотоодын шүүх дээр байсан тул энэ хоёр компани дээр гарсан зөрүүг хасахад шийдэгдээгүй зөрүүний нийт дүн **775 143** мянган төгрөг болж буурсан.

Хүснэгт 4. 2007 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (компаниар)

№	Компани	Анхны зөрүү	Залруулга	Шийдэгдээгүй зөрүү	Залруулга	Шийдэгдээгүй зөрүү
1	Айвенхоу майнз монголия инк	(691 852)	582 136	(109 716)		(109 716)
2	Адамасмайниниг	571 151	(573 997)	(2 846)		(2 846)
3	Алтандорнод монгол	(10 798 260)	-	(10 798 260)	10 798 260	-
4	Бүүргэнт	(26 643)	18 167	(8 476)		(8 476)
5	Багануур	107 763	(77 564)	30 199		30 199
6	Бороогоулд	(2 630 808)	2 425 384	(205 424)		(205 424)
7	Болд төмөр ерөө гол	(6 591 195)	6 423 839	(167 356)		(167 356)
8	Буд-Инвест	364	(4 364)	(4 000)		(4 000)
9	Гацуурт	494 822	(116 455)	378 367		378 367
10	Гоби коул энд энерги	978 043	(1 056 163)	(78 120)		(78 120)
11	Гурван төхөм	(39 159)	15 472	(23 687)		(23 687)
12	Дацантрейд	(271 662)	263 004	(8 658)		(8 658)
13	Жамп	51 932	(31 792)	20 140		20 140
14	Коулдголд монгол	558 290	(632 001)	(73 711)		(73 711)
15	Монгол чех металл	(11 428)	55 847	44 419		44 419
16	Монголрос-цветмет	(2 189 064)	2 047 109	(141 955)		(141 955)
17	Монголын Алт мак	(252 459)	141 457	(111 002)		(111 002)
18	Мондулаан трейд	(44 686)	24 916	(19 770)		(19 770)
19	Монполимет	(315 038)	424 739	109 701		109 701
20	Петрочайна дачин тамсаг	(5 234 532)	4 979 303	(255 229)		(255 229)
21	Сонортрейд	1 196	47	1 243		1 243
22	Тавантолгой	2 831 882	(2 863 521)	(31 639)		(31 639)
23	Тефис майнинг	(635 112)	614 570	(20 542)		(20 542)
24	Тун Синь	5 323		5 323	(5 323)	-
25	Улз гол	(15 620)	(175)	(15 795)		(15 795)
26	Хан шижир	36 776	(40 717)	(3 941)		(3 941)
27	Цайртминерал	(375 510)	374 898	(612)		(612)
28	Чинхуа мак нарийн сухайт	(2 466 521)	2 446 523	(19 998)		(19 998)
29	Шарын гол	150 390	(154 475)	(4 085)		(4 085)
30	Шанлун	(251 535)	(238 027)	(489 562)		(489 562)
31	Шижир-Алт	(3 458 286)	3 402 251	(56 035)		(56 035)
32	Шивээ-Овоо	274 366	(275 130)	(764)		(764)
33	Шим технологи	(1 019 422)	1 000 163	(19 259)		(19 259)
34	Шинь Шинь	(491 322)	487 204	(4 118)		(4 118)
35	Эрдмин	(227 333)	363 007	135 674		135 674
36	Эрдэнэт	35 269 622	(35 180 548)	89 074		89 074
37	Эрдэс холдинг	503 580	(203 244)	300 336		300 336
38	Элтрана	(19 378)	11 396	(7 982)		(7 982)
	Нийт	3 778 665	(15 346 742)	(11 568 077)	10 792 935	(775 143)

Алтан дорнод монгол ХХК, Тун шин ХХК мэдээлэл гаргаж өгөх боломжгүй, татварын маргаан нь олон улсын арбитрын болон дотоодын шүүх дээр байсан тул энэ хоёр компани дээр гарсан **10 792 935** мянган төгрөгний зөрүүг хасахад шийдэгдээгүй зөрүүний нийт дүн **775 143** мянган төгрөг болж буурсан.

2008 оны нэгдсэн тайлан

Монгол Улсын 2008 оны тайланд 100,0 сая-аас дээш материаллаг төлбөр төлсөн 46 компанийн, тэдгээрээс ЗГ-ын хүлээн авсан орлогыг хамруулсан болно. Энэхүү тайлангаар компаниуд 686,0 тэрбум төгрөгийн татвар, төлбөр төлснөө нотолсон бол Засгийн газар 684,9 тэрбум төгрөгийн орлогоо нотолж чадсан юм (Хүснэгт 5-аас үзнэ үү).

Тайланг нэгтгэхэд гарсан зөрүү

Шийдэгдээгүй их хэмжээний зөрүүнүүд байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал (-669,3 сая), хураамж, үйлчилгээний шимтгэл (-356,7 сая) гэсэн хэсгүүдэд гарсан. Харин татвар, төлбөр, хандивын хэсгүүд тус бүр 70 орчим сая төгрөгний буюу өмнөх онтой харьцуулахад бага хэмжээний шийдэгдээгүй зөрүү гарсан.

Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хувьд зардлын дүнг мэдээллийн өөр өөр эх үүсвэрээс авч тайланд бөглөсөнөөс зөрүүг шийдвэрлэх ямарч боломжгүй. Өөрөөр хэлбэл уул уурхайн компаниуд жил бүр "Байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"-г гаргаж өгдөг ба энэхүү 2008 оны нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын тайланг нэг бүрчлэн үзэхэд санхүүгийн тайлан бүртгэлд суурилагүй, компанийн геологичоос гаргасан бодит бус тайлан бичдэг болох нь тогтоогдсон. Иймээс зөрүүг шийдвэрлэх боломжгүй юм.

Хураамжийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс (-304,6 сая), улсын тэмдэгтийн болон бусад хураамж (-54,0 сая) зэргээс үүссэн.

Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлсний зөрүү үүссэн гол шалтгаан нь:

- Уг хураамжийг ЗГ-ын тайланд нэгтгэх мэдээллийн урсгал нь тодорхой бус, ОУИТБС-ын "Маягт-1"-ыг нөхөх арга аргачлалд ямар хураамж, үйлчилгээний хөлсийг тусгахыг нарийвчлан заагаагүй зэргээс шалтгаалсан.
- Компаниуд хураамж болон үйлчилгээний хөлсийг зардлын нэр төрлөөр тайлагнасан нь санхүүгийн тайланд тодорхой харагдахгүй байгаагаас ЗГ-ын нэгтгэл тайланд тусгагдахгүй байна.
- Компанийн тайлангийн дүнг тохируулах үүднээс орон нутгийн байгууллагууд руу тулган баталгаажуулах захидал илгээсэн хэдий ч орон нутгийн төрийн албан хаагчид хариу ирүүлэх ажилд санаачлага гаргахгүй, хариу ирүүлсэн ч бүрэн гүйцэд мэдээлж чадахгүй байна.

Татваруудын хувьд шийдэгдээгүй зөрүү нь голчлон гаалийн албан татвараас (-59,8 сая) үүссэн.

Төлбөрүүдийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (-18,2 сая), газрын төлбөр (-5,7 сая), ус, рашаан ашигласны төлбөр (-9,2 сая), гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр (-29,4 сая) зэргээс үүссэн.

Аудиторын санал зөвлөмж (Английн Харт Нойрс Лтд, Монгол улсын Улаанбаатар аудит ХХК-ийн консорциум)

- **Монголын ОУИТБС-ын зорилго, үйл ажиллагааг хуульчлах**
- **ОУИТБС-ын маягт дахь орлогын үзүүлэлт нэг бүрийн тодорхойлолтыг улам сайжруулж, боловсронгуй болгох** Орлогын үзүүлэлт нэг бүрийн хамрах хүрээ, тодорхойлолтыг гаргах. Энэ нь маягтыг зөв зүйтэй бөглөхөд үүсдэг эргэлзээ, тээнгэлзээг арилгахад тус дөхөм болно.
- **Компаниудын ОУИТБС-ын маягтаар хүргүүлэх мэдээлэл нь нэгтгэлийн баталгаатай уялдсан байх** Хамгийн бага хэмжээний дүнг тогтоох тал дээр анхаарах нь зүйтэй. Үүний үр дүнд,

тогтоосон хэмжээнээс доогуур хэмжээний төлбөр төлсөн компаниудыг нэгтгэлд хамруулахгүй байх, зарим талаараа ОУИТБС-ын хувьд нийт орлогын хэмжээнд материаллаг бус дүнтэй жижиг байгууллагуудын хувьд дарамт шахалт үзүүлэхгүй байх болно.

- **Засгийн газрын ОУИТБС-ын мэдээ, мэдээллийг цуглуулах болон тайлагнах үйл явц нь тодорхой хугацаанд аудитлагдаж байх** Өнөөгийн байдлаар ОУИТБС-ын үйл ажиллагааны хүрээнд ЗГ-ын үйл явцыг аудитлах тухай ямарваа нэгэн зүйл заалт байхгүй байгаа билээ. Тодорхой нэгэн хугацаанд давтамжтайгаар хянан шалгаж байх нь эдгээр үйл явц, процессуудыг сайжруулах, тэдгээрийг илүү үр дүнтэй явагдахад нөлөөлнө
- **Дэд-гүйцэтгэгч нарын тухайд** Монгол улсад зарим уул уурхайн компаниуд өөрийн уул уурхайн үйл ажиллагааг гүйцэтгүүлэх үүднээс дэд-гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажиллуулдаг. Жишээлбэл, өрөмдлөг, хөрс хуулалт, нөхөн сэргээлт зэрэг нь олборлох үйл ажиллагаатай шууд холбоотой юм. Тухайн дэд гүйцэтгэгч нар нь ОУИТБС-ын ажлын хэсгийн шалгуураар сонгогдсон компанийн ажлыг хамтран гүйцэтгэж байгаа учир тус дэд гүйцэтгэгчийн ЗГ-т төлсөн төлбөрийг ОУИТБС-ын тайланд оруулах ёстой.
- **Хандив, тусламжийн тухайд** Компаниудын тайлагнан ирүүлсэн хандив тусламжийн дүнгүүд нь ихэнх тохиолдолд ЗГ-т өгсөн бус харин сайн дурын болон нийгэм, олон нийтийн ашиг тусын (барилга, зам, дэд бүтэц гэх мэт) тулд өгсөн зардлуудыг харуулж байгаа билээ. Тиймээс АХ нь ОУИТБС-ын хандив, тусламжийн хүрээнд хамруулах зүйлсийн тодорхойлолтыг хянан үзэж, ЗГ-т төлөгдөөгүй дүнг оруулахгүй байх эсвэл сайн дурын үндсэн дээр тайлагнахыг компаниудаас шаардах, хандив, тусламжийг тайлагнах тал дээр хамгийн бага дүн хэмжээг тогтоож болох эсэхийг судлах.
- **Хураамж, үйлчилгээний шимтгэлийн тухайд** 2008 оны хувьд нийт залруулагдсан орлого болох 685 тэрбум төгрөгийн 2.5 тэрбум төгрөг нь ЗГ-ын нийт тайлагнасан хураамж, үйлчилгээний шимтгэл юм. Эдгээр шимтгэлүүд нь энэ удаагийн ОУИТБС-д хамрагдсан ЗГ-ын нийт хүлээн авсан дүнгийн зөвхөн 0.36%-г эзэлж байгаа ба энэ нь үнэхээр олборлох салбарын тайлагнагдах материаллаг орлого болох эсэх талаар АХ анхааран үзэх хэрэгтэй.
- **Байгаль орчин хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тухайд** Эдгээр зардлууд нь компаниудын зүгээс тайлагнагдсан хэдий ч ЗГ-ын байгууллагуудад төлөгдөөгүй, харин орон нутгийн гэрээлэгч талуудад төрөл бүрийн ажил гүйцэтгэсний хувьд төлөгдсөн. Тиймээс ямар нэгэн нэгтгэл хийгдэх нөхцөл үүсэхгүй байна.
- **Шийдэгдээгүй зөрүүнүүдийг шалгах шаардлага** Шийдэгдээгүй зөрүүнүүдийн талаар нилээн хүч хөдөлмөр гарган ажиллаж ЗГ-ын нийт хүлээн авсан дүнгийн 0.16% болтол нь бууруулсан хэдий ч мэдээлэл болон тайлбаруудыг цуглуулан авч, бүх зөрүүнүүдийг шийдвэрлэх боломжгүй байлаа. Тиймээс АХ нь цаашид энэ талаар хэрхэх тухай анхааран үзэж, зохих арга хэмжээ авах нь зүйтэй.
- **ЗГ-ын зарим агентлагуудын систем болон анхан шатны мэдээлэл бүрдэлтийг сайжруулах**
- **Компанийн аудитлагдсан санхүүгийн тайланд ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан мөнгөн урсгалын тайлан мэдээ бүхий тодруулгыг багтаах тухай** Энэхүү тодруулга нь мөнгөн сууриар бэлтгэгдэх ба санхүүгийн тайланд оруулсан тоон үзүүлэлтүүдтэй уялдаж компанийн хараат бус аудиторын гаргасан дүгнэлтэнд хамрагдсан байх хэрэгтэй.
- **Уул уурхайн болон газрын тосны компанийг МОУИТБС-д тусгайлан авч үзэх боломжийг судлах:** Уул уурхайн болон газрын тосны салбар хооронд ижил төстэй зүйлс байх хэдий ч тус бүрийн журам, дүрэм болон гэрээний нөхцөл байдлын үед ялгаатай хандах зүйл байдаг. АХ энэхүү байдлуудыг үнэлэн дүгнэж шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтүүдийг дараа дараагийн нэгтгэлийн ажилд оруулах нь зүйтэй.
- **Харилцаа холбооны тухай** Монгол улсын хувьд яам, агентлагууд нь орон нутагтайгаа холбоо барих үед харилцаа холбооны найдваргүй байдлаас болж, ялангуяа, цахилгаан хэлбэрээр /и-мэйл/ харилцаа тогтооход хүндрэлтэйн улмаас мэдээлэл дамжуулахад хэцүү төвөгтэй болдог. Энэ байдал нь мэдээллийн урсгалыг удаашруулж ярвигтай болгохын дээр шуудан холбоогоор мэдээ, мэдээлэл илгээж явуулах тохиолдолд алдагдах болон хасагдах нөхцөл үүсдэг. Үүнийг сайжруулах үүднээс, цахилгаан шуудангийн системтэй болгох, эсвэл, дундын цахилгаан мэдээллийн баазтай болгох зэрэг дээр анхаарах нь ажлын үр дүнг сайжруулах үр дүнтэй.

Хүснэгт 5. 2008 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (татвар, төлбөрийн төрлөөр)

Бүлэг	Засгийн газар	Компани	Анхны зөрүү	Залруулга		Залруулагдсан байдал		Шийдэг-дээгүй зөрүү	Залруул-га	Шийдэгдээгүй зөрүү
				Засгийн газар	Компани	Засгийн газар	Компани			
Татварууд	513 176 775	529 354 346	- 16 177 571	821 835	-15 428 524	513 998 609	513 925 822	72 787		72 787
Төлбөрүүд	117 144 724	118 715 936	- 1 571 212	- 11 678 010	-13 172 267	105 466 714	105 543 669	- 76 955		- 76 955
Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	2 434 776	2 918 513	- 483 737	52 050	- 74 897	2 486 826	2 843 616	- 356 790		- 356 790
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	27 349 905	21 133 422	6 216 483	-	6 216 483	27 349 905	27 349 905	-		-
Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	-	26 669 948	- 26 669 948	26 669 948	-	26 669 948	26 669 948	-		-
Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	1 048 225	10 364 538	- 9 316 313	4 893 179	- 4 353 078	5 941 404	6 011 460	- 70 056		- 70 056
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	4 580 546	3 727 118	853 428	- 1 540 781	- 17 960	3 039 765	3 709 158	- 669 393	679 511	10 118
Нийт	665 734 951	712 883 821	- 47 148 870	19 218 221	-26 830242	684953171	686 053 578	-1 100407	679 511	- 420 896

Шийдэгдээгүй зөрүү: Залруулга хийгдсэний дараа шийдэгдээгүй зөрүү **1 100 407** мянган төгрөг байсан боловч байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардлууд нь ЗГ-т мөнгөөр төлөгдсөн урсгал биш бөгөөд үүссэн зөрүүг залруулах боломжгүй нь нэгтгэл хийх явцад тодорхой болсон тул нийт шийдэгдээгүй зөрүүнээс хасаж тооцвол эцсийн байдлаарх шийдэгдээгүй зөрүү **420 896** мянган төгрөг болж байна.

Хүснэгт 6. 2008 оны нэгдсэн тайлангийн санхүүгийн урсгал (компаниар)

№	Компани	Анхны зөрүү	Залруулга		Шийдэгдээгүй зөрүү
			Засгийн газар	Компани	
1	Адамас майнинг	84,718	20,023	104,792	-51
2	Адуун чулуун	54	5,256	12,431	-7,121
3	Айвенхоу майнз монголия инк	(3,650,450)	190,545	(3,333,094)	-126,811
4	Анхай интернэйшнл	-74,557	81,552	6,995	(-)
5	АУМ	-268,522	30,128	-237,115	-1,279
6	Багануур	-325,358	249,746	-72,042	-3,57
7	Болд төмөр ерөө гол	-177,184	(1,163,321)	(1,230,755)	-109,75
8	Бороо гоулд	(7,763,628)	6,254,898	-368,569	(1,140,161)
9	Бэрлэг майнинг	124,775	2,9	127,681	-5
10	Гацуурт	(1,032,717)	-775,385	(1,808,102)	(-)
11	Гоби коул энд энержи	-87,306	170,745	97,012	-13,573
12	Дацан трейд	-24,037	1,572	-20,465	-2
13	Жамп	262,365	39,615	318,729	-16,749
14	Зүрийн булан	-212,625	211,758	10,033	-10,901
15	Коулд голд монгол	-25,719	25,757	38	-
16	Монгол алт	233,455	-11,218	222,237	-
17	Монгол газар	-376,113	-3,458	-481,317	101,747
18	Монгол цамхаг	126,924	44,721	171,635	10
19	Монголросцветмет	(2,880,297)	2,112,097	125,251	-893,452
20	Монголын алт МАК	-498,486	266,607	-188,946	-42,933
21	Монполимет	2,283,547	-96,861	2,186,686	(-)
22	Өрмөн уул	784,156	40,164	824,319	1
23	Петро чайна дачин тамсаг	(27,157,635)	27,136,184	-21,451	(-)
24	Сонор трейд	-30,255	42,206	11,894	56
25	Таван толгой	10,717,214	-597,555	10,075,525	44,133
26	Талбулаг трейд	-11,47	11,515	15	30
27	Тефис майнинг	-843,582	-15,897	-859,479	-
28	Тун синь	-577,903	530,144	-43,83	-3,929
29	Тэн хун	100,089	7,184	136,902	-29,629
30	Уулс заамар	-19,503	26,918	7,327	89
31	Үүрт гоулд	24,893	36,615	61,838	-330
32	Хан шижир	3,609	-8,998	-5,389	-
33	Хунанжинлэн	-26,34	28,393	7,839	-5,785
34	Цайрт минерал	(2,145,811)	576,337	(3,005,255)	1,435,782
35	Чинхуа МАК нарийн сухайт	-742,827	3,438,190	2,815,723	-120,361
36	Шанлун	-2,976	-10,518	-4,926	-8,567
37	Шарын гол	-49,209	85,584	47,491	-11,116
38	Шивээ овоо	-37,055	67,012	27,401	2,556
39	Шижир алт	-541,228	217,389	-323,839	(-)
40	Шижир талст	-3,151	1,205	-1,267	-679
41	Шинь шинь	(2,080,673)	194,849	(1,885,824)	(-)
42	Элтрана	-20,253	6,363	-10,991	-2,899
43	Энгүй тал	1,985,734	6,999	1,992,733	-
44	Эрдэнэт үйлдвэр	(12,471,165)	(20,232,277)	(32,573,343)	-130,099
45	Эрдэс холдинг	126,828	-188,458	-60,554	-1,076
46	Эрэл	150,801	161,336	313,784	-1,647
	Нийт	(47,148,870)	19,218,221	(26,830,242)	(1,100,407)